

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2018 ОНЫ 3 САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмал **7.8 (2.4%)** мян.тн, төмрийн хүдрийн баяжмал **209.7 (36.1%)** мян.тн, хайлуур жоншны баяжмал **2.0 (18.2%)** мян.тн, цайрын баяжмал **2.8 (13.6%)** мян.тн-оор тус тус өссөн байна.

Харин нүүрс **500.5 (4.3%)** мян.тн, алт **186.3 (9.1%)** кг, молибдены баяжмал **139.8 (9.6%)** тн, газрын тос **69.2 (3.8%)** мян.бар, катодын зэс **161.9 (4.3%)** тн-оор тус тус буурсан байна.

1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Салбар	Хэмжих нэгж	2017		2018*		Өөрчлөлт			
		III	I-III	III	I-III	5-3=?	5/3=?	6-4=?	6/4=?
1	2	3	4	5	6	7	8	9	10
НИЙТ ДҮН									
Уул уурхай, олборлох аж үйлдвэр									
Нүүрс	мян.тн	3,453.6	11,698.1	4,700.6	11,197.6	1,247.0	36.1%	(500.5)	-4.3%
Газрын тос	мян.бар	611.0	1,815.0	568.4	1,745.8	(42.6)	-7.0%	(69.2)	-3.8%
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	мян.тн	110.1	322.3	121.9	330.1	11.8	10.7%	7.8	2.4%
Молибдений баяжмал, металл агуулгаараа	тн	506.3	1,457.4	466.8	1,317.6	(39.5)	-7.8%	(139.8)	-9.6%
Алт	кг	673.3	2,057.1	594.8	1,870.8	(78.5)	-11.7%	(186.3)	-9.1%
Төмрийн хүдэр	мян.тн	240.5	477.1	359.3	1,154.7	118.8	49.4%	677.6	142.0%
Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	245.6	580.3	439.3	790.0	193.7	78.9%	209.7	36.1%
Хайлуур жонш	мян.тн	10.6	33.6	9.3	28.4	(1.3)	-12.3%	(5.2)	-15.5%
Хайлуур жоншны баяжмал	мян.тн	2.7	11.0	11.0	13.0	8.3	307.4%	2.0	18.2%
Цайрын баяжмал	мян.тн	6.9	20.6	8.5	23.4	1.6	23.2%	2.8	13.6%
Боловсруулах аж үйлдвэр									
Катодын зэс, 99%	тн	1,361.6	3,743.7	1,239.3	3,581.8	(122.3)	-9.0%	(161.9)	-4.3%
Металл бэлдэц	тн	1,763.3	5,577.2	3,571.7	8,001.6	1,808.4	102.6%	2,424.4	43.5%
Металл цувимал	тн	595.9	2,839.9	3,946.7	7,760.2	3,350.8	562.3%	4,920.3	173.3%

2. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн

2018 оны эхний улирлын байдлаар Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **3.8** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **580.6 (17.9%)** тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **2.7** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **466.2 (20.5%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүс олборлолт **1.0** их наяд төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс **297.4 (41.1%)** тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолт **1.4** их наяд төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс **147.1 (11.4%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2018 оны эхний улиралд **3.8** их наяд төгрөг хүрч **2.8** их наяд төгрөг буюу **73.7%**-ийг, уул уурхай, олборлох аж үйлдвэр **2.5** их наяд төгрөг буюу **64.9%**-ийг гадаад зах зээлд борлуулсан байна.